

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ БАЯНХОНГОР НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2020.08.07

Баянхонгор сум  
Есөнбулаг 9 дүгээр баг

ИНЕГ-ын даргын баталсан 2020 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн ИНЕГ-ын харьяа Баянхонгор аймаг дахь Баянхонгор нисэх буудлын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай 20/20 тоот удирдамжийн хүрээнд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны ахлах аудитор Л.Жаргалсайхан, аудитор А.Мөнх-Эрдэнэ, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Б.Болормаа нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2020 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 08 дугаар сарын 06-ны өдрийг дуустал хугацаанд дотоод аудитыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Баянхонгор нисэх буудлын 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацааны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, нягтлан бодох бүртгэл, цалин хөлсний бодолт, олголт, төсөв гүйцэтгэл, дотоод хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус багийн үйл ажиллагаа, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Нисэх буудлын 2019 оны санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас аудит хийж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргасан байна.

Нислэгийн хөдөлгөөний хэсэг, Холбоо, навигаци, цахилгааны хэсэг, Газрын тусгай үйлчилгээний хэсэг, Аюулгүй байдлын хэсэг болон уурын зуухны баг нь 2020 онд хийх ажлын төлөвлөгөөгөө боловсруулж нисэх буудлын даргаар батлуулж, төлөвлөсний дагуу ажлаа гүйцэтгэж тайлагнаж байна.

Галын бүлгийн, хөдөлмөр, хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйг хангах ажлын, коронавирусын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын, өмч хамгаалах зөвлөлийн хийх ажлын, үндсэн хөрөнгийн тооллогын комиссын хийх ажлын, баримт бичиг нягтлан шалгах комиссын хийх ажлын, дотоод хяналтын багийн төлөвлөгөөг боловсруулан нисэх буудлын даргаар батлуулан хэрэгжүүлж байна.

Аймаг, орон нутаг болон байгууллагаа сурталчлах, хийсэн бүтээснээ бусдад таниулах зорилгоор “Бид Хонгор Нутгийн Менежер” челленж аяныг санаачлан хэрэгжүүлсэн байна.

Татаасын нислэгтэй болсноор “Сэтгэлд дулаан нисэх” хөтөлбөр хэрэгжүүлж, зорчигчийн ачаа тээшийг ачиж, буулгахдаа “шилэн ачаа” үйлчилгээг нэвтрүүлэх, зорчигч үйлчлүүлэгчээ хүндлээ уриатай ажиллах зэрэг зорчигч, үйлчлүүлэгч нарт чиглэсэн шинэлэг ажлуудыг санаачилжээ.

Ажлын байр, байгууллагын орчин нөхцөлөө сайжруулах зорилгоор нийт ажилчдын дунд 3 сарын хугацаатай ажлын байрны эмх цэгц, зохион байгуулалтыг сайжруулах бүтээлч ажлын болзолт уралдаан зарласан байна. Зорчигч, үйлчлүүлэгчдийн ая тухтай байдлыг хангах зорилгоор нисэх буудлын дотоод орчны тохижилтыг хийсэн байна.

Нисэх буудлын ажилчдын болон аймаг, орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандивын хөрөнгөөр “Нислэг” цэцэрлэгт хүрээлэнг нисэх буудлын орчинд ажилчдын хүч хөдөлмөрөөр босгосон ба хамт олны санаачилга, хөдөлмөр зүтгэлээр бүтээгдсэн уг усан оргилуур нь аймгийн төвийн иргэд, байгууллагуудын дунд үлгэр жишээ болсон бүтээлч ажил байна.

Нисэх буудлын барилгын өнгө төрхийг сайжруулах зорилгоор буудлын барилгын гадна фасадыг шинэчлэхээр аймгийн ИТХ, Засаг даргын төсвөөс 150.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлжээ.

Цалин хөлс, түүнтэй адилтгах бусад мөнгөн тооцоогоор зөрчил гаргаагүй.

Нисэх буудлын даргын гаргасан тушаалын дугаар засвартай, үндэслэл хэсэгт хууль, дүрэм, журмын заалтыг буруу бичих, “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”-ын стандартыг зөрчих зэрэг зөрчлүүд нийтлэг байна.

Санхүүгийн програм дээр бусад салбар, нэгж дээр хэрэглэхээр үүсгэсэн бараа материалын бүлгийг сонгож гүйлгээг хийснээс бараа материалын бүлэг буруу бүртгэгдэж байна. Бараа материалын зарлага гаргахдаа шаардах хуудас болон зарлагын баримтыг цаг хугацаанд нь бичээгүй. Эдэлгээний хугацаа урт сэлбэг, материалыг эд хариуцагчийн нэр дээр эзэмшигчийн карт бүртгэл хөтлөөгүй.

Ажиллагсдаас авах авлагыг барагдуулах талаар ажиллаж байгаа ч дорвитой үр дүнд хүрээгүй байна.

Автомашин гүйлтийг спидометрийн заалттай тулгалгүйгээр шатахууны тооцоог хийсэн. Авто тээврийн хэрэгслийн болон дизель генераторын хувийн хэргийг хариуцсан ажилтан нь бүрэн хөтлөөгүй байна.

Дизель генераторуудын мотоцагийн заалттай уялдуулж шатахууны тооцоог хийгээгүй, эрчим хүч тасалдсан тохиолдолд дизель генератор ажиллуулахдаа аймгийн эрчим хүчний байгууллагын тодорхойлолтыг тогтмол аваагүй байна.

Шилэн дансны цахим системд мөнгөн дүнг буруу мэдээлсэн, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ шийдвэрийн хуулбарыг хавсаргаагүй.

Дотоод хяналт, шалгалтын баг нь дотоод аудит хийхдээ тухай бүрт удирдамж боловсруулаагүй, шалгах хуудасны асуулга хангалтгүй, илэрсэн асуудлыг дүгнээгүй, зөвлөмжийн хэрэгжилтийг гаргаагүй байна.

Шатахууны тооллогоор 111.19 кг түлш илүүдсэн бөгөөд илэрсэн зөрүү нь хэмжилтийн зөвшөөрөгдөх алдааны хэмжээнээс 21.68 кг-аар илүү байна. Тооллого бүрт түлш байнга илүүддэг ба шалтгаан нь тодорхойгүй байна.

Гадны байгууллага, иргэдтэй гэрээ байгуулахдаа огноо бичээгүй, эрх бүхий албан тушаалтан батлаагүй, дугаарлаагүй, гэрээний бүртгэл дутуу, гэрээг дүгнээгүй зөрчил түгээмэл байна.

Зам, тээврийн салбарын хэмжээнд 2020 оныг “Сахилга хариуцлага-Хөдөлмөрийн аюулгүй байдлын жил” болгон зарласантай холбогдуулан Хөдөлмөрийн аюулгүй байдал,

эрүүл ахуйн тухай хууль, холбогдох стандарт, дүрэм журмыг мөрдөж ажиллах, хяналт шалгалтын үр өгөөжийг дээшлүүлэх, сахилга хариуцлагыг чангатгах, тайлангийн чанар байдал, эргэн хяналт, зөвлөмжийн хэрэгжилтэд анхаарч ажиллах шаардлагатай.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар Иргэний нисэхийн үндэсний төвд 3, тус нисэх буудалд 12, нийт 15 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА